БАТЛАВ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ДЭД САЙД Л.ХАЛТАР

## УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХАД ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТҮВШИНД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ | Хугацаа | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Үндсэн | Хамтран |
| 1 | "Хөшигийн хөндийн НОБ" ТӨХХК болон Японы консорциум хооронд хамтран ажиллах Түншлэлийн гэрээг шинэчлэн байгуулах | 2018.10.05 | Түншлэлийн гэрээг байгуулсан байх | ЗТХЯ-ны АТБХЗХ | "Хөшигийн хөндийн НОБ" ТӨХХК |
| 2 | Концессын гэрээний ээлжит хэлэлцээ дээр санхүүгийн загвар, газрын үйлчилгээ болон аюулгүй байдлын үйл ажиллагааг эрхлэн явуулах этгээд, гэрээний албан ёсны хэл, Японы консорциумын оролцогч болон тэдний эзэмшиж буй хувь хэмжээ өөрчлөх эсэх, концессын зүйлд хамаарах газрын асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх. | 2018.09.20 | Зөвшилцөлд хүрч, гэрээний төсөлд тусгах | Дэд ажлын хэсэг | |
| 3 | Японы консорциумтай Хувьцааны төсөл дээр тохирох | 2018.10.12 | Хувьцаа эзэмшигчдийн гэрээний төсөл дээр тохирох | ЗТХЯ-ны АТБХЗХ | "Хөшигийн хөндийн НОБ" ТӨХХК |
| 4 | "УБХОУНОШБ-ын менежмент төсөл" болон холбогдох гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах | 2018.10.10 | Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байх | ЗТХЯ-ны АТБХЗХ | ҮХГ Ажлын хэсэг |
| 5 | УБХОУНОШБ-ын менежмент төслийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдтэй концессын хэлцлийг хийж, ҮХГ-т гэрээ байгуулах эрх олгох | 2018.10.25 | Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн, гэрээ байгуулагдсан байх. | ЗТХЯ-ны АТБХЗХ | ҮХГ ИНЕГ Ажлын хэсэг |
| 6 | УБХОУНОШБ-д монголын талын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй аэродромын үйлчилгээний барилга, ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилга, захиргааны барилгын ажлын үнийн зөрүү болох 6,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2019 оны төсөвт тусган, шийдвэрлүүлэх. | 2018.11.15 | Төсөвт тусгаж шийдвэрлэсэн байх. | ЗТХЯ-ны АТБХЗХ ХОҮХ | СЯ Төсөл хэрэгжүүлэх нэж |
| 7 | ИНЕГ-т нисэх буудлын зориулалтаар Тусгай хэрэгцээний газар (Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Хөшигийн хөндий дэхь УБХОУНОШБ)-аас 1200 га газар нэмж эзэмшүүлж, газрын гэрчилгээ авч баталгаажуулах /ЗГ-ын 2017 оны 105 дугаар тогтоолын 2 дугаар зүйл/ | 2018.12.01 | Газар эзэмших гэрчилгээг олгосон байх. | ИНЕГ | Төв аймгийн ЗДТГ Сэргэлэн сумын ЗДТГ |
| 8 | УБХОУНОШБ-ын менежмент төслийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох хувьд хөрөнгө оруулах болон нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах 42.784.200 000 (дөчин хоёр тэрбум | 2018.12.01 | Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх | СЯ ЗТХЯ-ны АТБХЗХ | ИНЕГ |



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | долоон зуун наян дөрвөн сая хоёр зуун мянган) төгрөгийн хөрөнгийг ИНЕГ хариуцан шийдвэрлэх /ЗГ-ын 2017 оны 322 дугаар тогтоолын 5 дугаар зүйл/ | | | | |
| 9 | "Чингис хаан" олон улсын нисэх буудлыг УБХОУНОШБ руу шилжүүлсэн тохиолдолд Буянт-Ухаа дахь одоогийн барилга байгууламжийн өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбоотой асуудлыг шийдвэрлэх. /ЗГ-ын 2017.11.29-ны өдрийн 50 дугаар тэмдэглэлийн 2 дахь заалт/ | 2018.12.01 | Буянт-Ухаа дахь олон улсын нисэх буудлын ашиглалтыг шийдвэрлэсэн байх | ЗТХЯ-ны АТБХЗХ | ИНЕГ |
| 10 | УБХОУНОШБ-ыг олон улсын боомт болгох, боомтын зэрэглэл тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх /ЗГ-ын 2017 оны 105 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл/ | 2018.12.25 | Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэсэн байх. | СЯ ХЗДХЯ | ЗТХЯ-ны АТБХЗХ |
| 11 | Агаарын хөлгийн шатахуун хангамжийн гидрант системийн үйл ажиллагааны схемийг тодорхойлж, шатахуун хангамжийн үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгжийг судалж, шийдвэрлэх /ЗГ-ын 2017.08.17-ны өдрийн 36 дугаар тэмдэглэлийн 7.4 дэх заалт, ЗГ-ын 2018 оны 223 дугаар тогтоол/ | 2018.12.25 | Судалж шийдвэрлэсэн байх | ҮХГ | ЗТХЯ-ны АТБХЗХ ТӨБЗГ ИНЕГ |
| 12 | "УБХОУНОШБ барих төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийн санхүүгийн үйл ажиллагаа, төслийн зээлийн захиран зарцуулалтад хяналт шалгалт хийх хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үр дүн, дүгнэлт, саналаа Засгийн газарт танилцуулах /ЗГ-ын 2017.08.17-ны өдрийн 36 дугаар тэмдэглэлийн 7.6 дахь заалт/ | 2018.12.25 | Засгийн газарт танилцуулсан байх | СЯ ЗТХЯ-ны АТБХЗХ БХБЯ | |
| 13 | УБХОУНОШБ-ыг агаарын хөлгийн ТС-1 болон Жет А-1 төрлийн шатахуунаар хангах хос байгууламжтай болгох, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж байгаа Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид агаарын хөлгийн шатахуун шилжүүлэн ачих технологийн шугамын өргөтгөл хийх, Жет А-1 төрлийн шатахуун импортоор оруулах боломжийг бүрдүүлэх асуудлыг судлах, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа Засгийн газарт танилцуулах /ЗГ-ын 2017.03.29-ний өдрийн 14 дүгээр тэмдэглэлийн 2 дахь хэсэг/ | 2018.12.25 | Засгийн газарт танилцуулсан байх | ЗТХЯ-ны АТБХЗХ УУХҮЯ | |
| 14 | УБХОУНОШБ-ын шатахуун хангамжийн гидрант системийг төлөвлөсөн хүчин чадалд хүргэх боломж мөн техникийн шаардлагад нийцээгүй ч хүлээн авч ашиглах боломжтой эсэх талаар дүгнэлт, шийдлийг ИНЕГ, Төслийн Зөвлөх компаниас гаргуулж улсын комисст хүлээлгэн өгөх. | 2018.12.28 | Шатахуун хангамжийн гидрант системийг хүлээн авсан байх. | ЗТХЯ-ны АТБХЗХ | ИНЕГ Төсөл хэрэгжүүлэх нэгж |
| 15 | "Хөшигийн хөндийн НОБ" ТӨХХК-ийн 2018 оны үйл ажиллагааны зардлыг ИНЕГ-ын батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх /ЗГ-ын 2018 оны 150 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл/ | 2019.01.01 | Төсөвт зохицуулалт хийж санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх. 2019.01.01.Бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэн байх. | ЗТХЯ-ны АТБХЗХ СЯ ИНЕГ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | УБХОУНОШБ-ын барилга байгууламж, өмч хөрөнгийг төрийн өмчид бүртгэн авч, ИНЕГ-ын балансад бүртгэх ажлыг зохион байгуулах /ЗГ-ын 2018 оны 150 дугаар тогтоолын 5 дугаар зүйл/ | 2019.03.01 | Барилга байгууламж, өмч хөрөнгийг ИНЕГ-д бүртгэсэн байх. | ЗТХЯ-ны АТБХЗХ ТӨБЗГ | ИНЕГ |
| 17 | Тусгай хэрэгцээний газартай давхацсан, холбогдох хууль тогтоомж зөрчиж газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон, газар эзэмших талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, давхцалыг арилгах арга хэмжээ авах /ЗГ-ын 2017 оны 105 дугаар тогтоолын 3 дугаар зүйл/ | 2019.03.25 | Тусгай хэрэгцээний газрын давхцалын асуудлыг шийдвэрлэсэн байх. | БХБЯ ЗТХЯ-ны АТБХЗХ Төв аймгийн ЗДТГ | |
| 18 | Засгийн газрын 2012 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-нд тодотгол хийж, шинэ хот байгуулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулахад дэмжлэг үзүүлэх /ЗГ-ын 2017 оны 105 дугаар тогтоолын 5 дугаар зүйл/ | 2019.03.25 | Ерөнхий төлөвлөгөөний тодотголын төслийг боловсруулсан байх 2019.03.25. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байх. | БХБЯ ЗТХЯ-ны АТБХЗХ НЗДТГ Төв аймгийн ЗДТГ | |
| 19 | УБХОУНОШБ-ын шатахуун хангамжийн байгууламжийн менежмент төслийг концессын гэрээгээр хэрэгжүүлэх. /ЗГ-ын 2018 оны 223 дугаар тогтоол/ | 2018.11.01 | Шатахуун хангамжийн байгууламж барих ажлыг концессын гэрээгээр хэрэгжүүлсэн байх. | ҮХГ | УУХҮЯ ЗТХЯ-ны АТБХЗХ ИНЕГ |
| 20 | УБХОУНОШБ-ыг цахилгааны нэмэлт эх үүсвэрээр хангах эрчим хүчний дэд станц барьж, шугам сүлжээнд холбох зохион байгуулалтын арга хэмжээ авах /ЗГ-ын 2017 оны 105 дугаар тогтоолын 6 дугаар зүйл/ | 2019.10.20 | Цахилгааны нэмэлт эх үүсвэрийг тодорхой болгосон байх. 2019.10.20. Нэмэлт эх үүсвэрээр хангах асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байх. | ЭХЯ | ЗТХЯ-ны АТБХЗХ ИНЕГ |
| 21 | УБХОУНОШБ-ын менежмент төслийн зээлийн үлдэгдэл хөрөнгөөр ангарын барилга байгууламж барих ажлыг хэрэгжүүлж, ашиглалтад оруулах /ЗГ-ын 2017.08.17-ны өдрийн 36 дугаар тэмдэглэлийн 7.2 дахь заалт/ | 2019.10.20 | Ангарын барилгын ажлыг бүрэн дуусгасан байх; 2019.10.20. Ашиглалтад оруулсан байх | СЯ ЗТХЯ-ны АТБХЗХ | ИНЕГ |
| 22 | Зорчигчийн хоол бэлтгэх зориулалт бүхий кейтерингийн барилгыг "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" нөхцөлөөр гүйцэтгүүлж, ашиглалтад оруулах /ЗГ-ын 2017.08.17-ны өдрийн 36 дугаар тэмдэглэлийн 7.5 дахь заалт, ЗГ-ын 2017 оны 277 дугаар тогтоол / | 2019.10.20 | Ашиглалтад оруулсан байх | ҮХГ | ЗТХЯ -ны АТБХЗХ ИНЕГ |

--- oOo---

**Товчилсон үгийн тайлбар**

| | |
|---|---|
| АТБХЗХ | Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс |
| Ажлын хэсэг | Ерөнхий сайдын 2018 оны 102 дугаар захирамжаар байгуулсан "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг |
| БХБЯ | Барилга хот байгуулалтын яам |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗГ | Засгийн газар |
| НЗДТГ | Нийслэлийн засаг даргын тамгын газар |
| ИНЕГ | Иргэний нисэхийн ерөнхий газар |
| СЯ | Сангийн яам |
| УБХОУНОШБ | Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал |
| УУХҮЯ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам |
| ҮХГ | Үндэсний хөгжлийн газар |
| "Хөшигийн хөндийн НОБ" ТӨХХК | "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| ХОҮХ | Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| Төсөл хэрэгжүүлэх нэгж | Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл хэрэгжүүлэх нэгж |
| ЭХЯ | Эрчим хүчний яам |

**Зөвшөөрсөн:**

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА Б.БАЯРСАЙХАН

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Л.БЯМБАСҮРЭН

"ХӨШИГИЙН ХӨНДИЙН НОБ" ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ГАНТӨГС

"УБХОУНОШБ" БАРИХ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХБАТ

**Хянасан:**

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ АТБХЗХ-ИЙН ДАРГА Д.МЯГМАРСҮРЭН